ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АХИМ ББСБ” ХХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: 2023/ … /СТА-Б/

Хаяг: УБ Таур оффис, 609 тоот, 6-р давхар, 25-р хороо, БЗД, Улаанбаатар хот, Монгол улс Гүйцэтгэх захирал: Э.Булган Утас: 7740-4848	Гэрээт ажлын Аудитор: У.Нарандэлгэр Утас: 9990-4601 Цахим хаяг:narandelger.u@nexiamongolia.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

“АХИМ” ББСБ-ын

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
3. ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
4. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
5. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

- ББСБ-ын ерөнхий мэдээлэл
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Зээлийн хөрөнгийн авлага
- Бусад хөрөнгө
- Үндсэн хөрөнгө
- Татварын өр
- Хувь нийлүүлсэн хөрөнгө
- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого
- Хүүгийн зардал
- Хүүгийн бус зардал
- Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ
- Болзошгүй хүчин зүйлс болон түүний үүрэг
- Тайлант хугацааны дараах үйл явдал

Хуудас №
АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АХИМ ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

Аудиторын дүгнэлт

“АХИМ ББСБ” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх ББСБ-ын санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

ББСБ-ын удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Удирдлага нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

Хуудас №2

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- **Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.**

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.

- **Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалттүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.**

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид, Партнер,

Аудитор У.Нарандэлгэр Э.Булган

2023 оны 03-р сарын 20-ны өдөр

2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мян.төгрөг)

№	Балансын зүйл	тодруулга	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	**Мөнгөн хөрөнгө**	**6.1**	**93,583**	**143,661**
1.1	Бэлэн мөнгө		25,601	29,942
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах		67,982	113,719
2	**Зээлийн хөрөнгө /цэврээр/**	**6.2**	**1,523,981**	**1,579,463**
2.1	**Зээл**		**1,695,725**	**1,836,281**
2.1.2	Хэвийн зээл		1,451,329	1,380,062
2.1.3	Хугацаа хэтэрсэн зээл		9,360	56,468
2.1.4	Чанаргүй зээл:		235,036	399,751
2.1.5	(Зээлийн эрсдэлийн сан)		(193,132)	(308,858)
2.1.6	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага		21,388	52,040
3	**Бусад хөрөнгө**	**6.3**	**409,183**	**153,208**
3.1	Бусад авлага		269,630	1,428
3.2	Урьдчилж төлсөн тооцоо		135,989	150,657
3.3	Материал, үнэ бүхий зүйлс		3,563	1,122
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн			**2,026,747**	**1,876,332**
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
4	**Үндсэн хөрөнгө /цэврээр/**	**6.4**	**53,025**	**289,012**
4.1	Тавилга Эд хогшил		79,920	61,404
	Хуримтлагдсан элэгдэл		(30,728)	(23,263)
4.2	Техник хэрэгсэл		24,489	20,395
	Хуримтлагдсан элэгдэл		(20,656)	(19,923)
4.3	Дуусаагүй барилга		-	**250,400**
Эргэлтийн бус хөрөнгийн дүн			**53,025**	**289,012**
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**2,079,772**	**2,165,345**
	ӨР ТӨЛБӨР			
5	**Бусад өр төлбөр**	**6.5**	**27,174**	**45,975**
5.1	Богино хугацаат өглөг		4,215	2,473
5.2	ХАОАТ-ын өглөг		3,301	18,420
5.3	Орлогын албан татварын өглөг		19,658	25,082
	Нийт өр төлбөрийн дүн		**27,174**	**45,975**
6	**ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ**	**6.6**		
6.1	Энгийн хувьцаа		1,900,000	1,900,000
	Хувьцаат капиталын дүн		**1,900,000**	**1,900,000**
7	Хуримтлагдсан ашиг		152,598	219,370
8	**Эзэмшигчдийн өмчийн дүн**		**2,052,598**	**2,119,370**
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН		**2,079,772**	**2,165,345**

Хуудас №
АУДИТ

3. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мян.төгрөг)

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНТ ОНЫ ДҮН	ӨМНӨХ ОНЫ ДҮН
1	**ХҮҮГИЙН ОРЛОГО**	**403,977**	**447,839**
1.1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	294,823	447,839
1.2	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	109,153	-
2	**ХҮҮГИЙН ЗАРДАЛ**	-	-
3	**ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО**	**403,977**	**447,839**
4	**ХҮҮГИЙН БУС ОРЛОГО**	115,643	6,502
4.1	Санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн орлого	1,066	6,502
4.3	Бусад орлого /ЗЭСангийн буцаалт	114,577	-
5	**ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ**	**323,042**	**200,782**
5.1.1	Гадаад валютын ханшны тэгшитгэлийн зардал		
5.1.2	Зээлийн эрсдлийн сангийн зардал	-	8,209
5.2	**Боловсон хүчний холбогдолтой зардал**	**157,027**	**144,078**
5.2.1	Үндсэн болон нэмэгдэл цалингийн зардал	139,508	124,916
5.2.2	Ажилтанд олгосон тэтгэмж	-	2,460
5.2.3	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын зардал	17,518	16,702
5.3	**БУСАД ЗАРДАЛ**	**166,015**	**48,495**
5.3.1	Сургалтын зардал	90	265
5.3.2	Албан томилолт	-	426
5.3.3	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	2,908	1,180
5.3.4	Аудитын төлбөр	1,100	1,100
5.3.5	Түрээсийн зардал	56,000	
5.3.6	Зохицуулалтын хураамжийн зардал	2,700	3,300
5.3.7	Ашиглалтын зардал /цахилгаан, уур, ус, дулаан/	13,996	3,489
5.3.8	Элэгдэл хорогдол	8,197	9,315
5.3.9	Харилцаа холбоо интернет	5,332	4,804
5.3.10	Шатахуун болон тээврийн зардал	5,710	3175
5.3.11	Шимтгэлийн зардал	280	-
5.3.12	Бараа материал, хангамжийн зардал	17,525	-
5.3.13	Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	6,196	5,094
5.3.14	Зар сурталчилгаа маркетингийн зардал	35	
5.3.15	Бичиг хэргийн зардал	2,070	2,087
5.3.16	Ариун цэврийн зардал	1,042	941
5.3.17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,005	4,010
5.3.18	Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	40,829	9,309
6	**ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО /ЗАРДЛЫН ДҮН**	**(207,399)**	**(194,280)**
7	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ**	196,578	253,560
8	**ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ**	**(36,512)**	**(10,522)**
9	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	36,512	10,522
9.1	Үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал	28,602	2,362
9.2	Баяр ёслол	40	7,460
9.3	Бусад зардал	7,870	700
10	**ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ / АЛДАГДАЛ**	**160,066**	**243,038**
11	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/ АЛДАГДАЛ	160,066	243,038
12	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	19,658	25,356
13	**ЦЭВЭР АШИГ**	**140,408**	**217,682**

Хуудас №
АУДИТ

4. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мян.төгрөг)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	**1,900,000**	**199,813**	**2,099,813**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	6,875	6,875
Залруулсан үлдэгдэл	**1,900,000**	**206,688**	**2,106,688**
Тайлант үеийн цэвэр ашиг		217,682	217,682
Хувиарласан Ногдол ашиг		(205,000)	(205,000)
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	**1,900,000**	**219,370**	**2,119,370**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		22,820	22,820
Залруулсан үлдэгдэл	**1,900,000**	**242,190**	**2,142,190**
Тайлант үеийн цэвэр ашиг		140,408	140,408
Хувиарласан Ногдол ашиг		(230,000)	(230,000)
		-	-
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	**1,900,000**	**152,598**	**2,052,598**

Хуудас №

5. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(мян.төгрөг)

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНТ ОНЫ ДҮН	ӨМНӨХ ОНЫ ДҮН
1	**Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн**	**- 56,873**	**61,753**
1.1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**1,795,084**	**1,646,589**
1.1.1	Зээлийн хүүгийн орлого	434,917	1,639,710
1.1.2	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,066	6,879
1.1.3	Бусад орлого /төлсөн зээл	1,359,101	-
1.2	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**1,851,957**	**1,584,836**
1.2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	115,882	102,164
1.2.2	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	32,999	28,696
1.2.3	Албан томилолт, сургалтын зардал	7,030	691
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	14,287	4,132
1.2.5	Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,643	8,664
1.2.6	Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	3,887	2,102
1.2.7	Татвар, даатгалын төлсөн мөнгө	77,213	31,521
1.2.8	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	3,372	-
1.2.9	Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	6,200	1,100
1.2.10	Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	2,700	3,300
1.2.11	Ногдол ашгаар олгосон мөнгө	207,000	184,500
1.2.12	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	1,217,492	1,199,608
1.2.13	Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө /олгосон зээл	147,254	18,359
2	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**6,795**	**(10,522)**
2.1	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого**	**37,885**	**-**
2.1.1	Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Бусад орлого	37,885	-
2.2	**Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**31,090**	**10,522**
2.2.1	Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	14,106	8,160
2.2.2	Бусад зардал	16,984	2,362
3	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**- 50,078**	**51,231**
4.1	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	143,661	92,430
4.2	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	93,583	143,661

Хуудас №

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

6.1 ББСБ-ын Ерөнхий Мэдээлэл

“АХИМ ББСБ” ХХК (цаашид “ББСБ” гэх)-ийн

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9015005067, *регистрийн дугаар*: 5908264

Үүсгэн байгуулсан шийдвэр: 2014 оны 12-р сарын 01-ны өдрийн шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Тусгай зөвшөөрөл: Монгол улс, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1-р сарын 28-ны өдрийн №89 тогтоолоор ТЗ 101/455 дугаар гэрчилгээтэй “Зээлийн үйл ажиллагаа” эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Хувьцаа эзэмшигч:

2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх хүчин төгөлдөр Компанийн дүрмэнд Монгол улсын иргэн Дашдорж овогтой Нарантунгалаг /РД:ХГ70060463/ нь 100% буюу нийт 1,900,000,000 төгрөгийн 190,000 ширхэг хувьцаа эзэмшдэг.

Гүйцэтгэх захирал: Монгол улсын иргэн Н.Шинэчимэг 99007692 /РД:ТД76030800/

Компанийн хаяг: УБ хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19 дүгээр хороолол /17030/, чингисийн өргөн чөлөө гудамж 39 байр 804, 805 тоот, 70187078,

Утас: 9994-3363, *e-mail*: akhimbbsb@gmail.com

6.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Тайлан бэлтгэх үндэслэл.

Санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэхээс бусдаар түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн болно. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Цаашид, эдгээрээс өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай хэрэглэгдсэн болно.

Тайлагналын мөнгөн нэгж.

Санхүүгийн тайлангуудыг ББСБ-ын үйл ажиллагааны мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Санхүүгийн хэрэглүүрүүд *– үндсэн нэр томъёонууд.* Санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнээр харин дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ нь хөрөнгийн бирж болон бусад байгууллагаас олон нийтэд тогтмол зарлагддаг эсвэл бэлэн олдох боломж бөгөөд эдгээр үнээр зах зээл дээр тогтмол бодит гүйлгээ холбоогүй этгээдүүдийн хооронд хийгддэг тохиолдолд тухайн санхүүгийн хэрэглүүрийг идэвхтэй зах зээл дээр бодит үнэ цэнэ нь тогтоогдсон гэж үзнэ.

Гүйлгээний зардлууд

Зээл олгох эсвэл төлүүлэхтэй шууд холбоотой нэмэлт зардал юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй зардал юм.

Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт болон нэмэгдэл, санхүүжилтийн зардал, удирдлагын болон хадгалалтын зардлууд орохгүй.

Хуудас №2

Хорогдуулсан өртөг

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн аливаа эргэн төлөлтийг хасч, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа алдагдалыг хассан дүн болно. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл болон хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүний аргаар тооцсон хорогдуулалт орно.

Санхүүгийн хөрөнгийн ангилал.

Санхүүгийн хөрөнгө нь дараах ангилалтай байна: (а) зээл болон авлага, (б) борлуулахад бэлэн байгаа санхүүгийн хөрөнгө, (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө, болон (г) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого үр дүнгийн тайланд тусгагддаг санхүүгийн хөрөнгө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого үр дүнгийн тайланд тусгагддаг санхүүгийн хөрөнгө нь дараах дэд хэсгүүдээс бүрдэнэ: (1) анх хүлээн зөвшөөрөгдөхдөө энэ хэсэгт ангилагдсан хөрөнгө, (2) арилжааны зориулалтай эзэмших гэж ангилагдсан хөрөнгө.

ББСБ-ын *2022 оны 12 дугаар сарын 31-ний* өдрийн бүх санхүүгийн хөрөнгө нь **зээл болон хүүгийн авлага** гэж ангилагдсан.

Зээл болон хүүгийн авлагууд

Хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд санал болгоогүй, дериватив бус, төлбөр нь тогтмол буюу тодорхойлох боломжтой санхүүгийн хөрөнгө болно.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ББСБ нь дараах санхүүгийн хөрөнгийг СТОУС-ын хэмжилтийн зорилгоор зээл, хуримтлагдсан хүүгийн авлага, зээлийн эрсдлийн сангийн хорогдуулалт гэж ангилсан.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал.

ББСБ-ын бүх санхүүгийн өр төлбөр нь бусад өр төлбөрүүдийн ангилалд багтсан ба хорогдуулсан өртгөөрөө бүртгэгдсэн. *2022 оны 12 дугаар сарын 31-нээрх* ББСБ-ын санхүүгийн бүх өр төлбөрт тайлант жилийн татварын өглөг байна.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх буюу бүртгэлээс хасах.

ББСБ нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна. Үүнд:

(а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон,

(б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн тохиолдлууд болно.

Орлогын албан татвар.

2020 оноос хэрэгжиж байгаа ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу тайлант үеийн Орлогын албан татварыг 10% ба, ТНОрлого 300 сая хүртэл төгрөг бол 1% хувиар ногдуулна.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн. СТОУС болон Монгол улсын татварын хууль тогтоомжийн заалтуудын хооронд үүсэх зөрүүнүүд нь хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлагналын дүн болон татварын суурь хооронд түр зөрүүгээр үүснэ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ).

Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын тухай хуулийн дагуу санхүүгийн үйлчилгээ (зээл олгох) НӨАТ-аас чөлөөлөгдөх бөгөөд ББСБ-ын санхүүгийн бус үйлчилгээний үйл ажиллагаанаас байгууллагад НӨАТ-ын өр төлбөр үүсээгүй. Иймд ББСБ нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй болно.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд тодорхой хэмжээний бэлэн мөнгөнд түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө, банкин дах харилцах болон хугацаагүй хадгаламж, анхлан 3 сар болон түүнээс богино хугацаатай хадгалуулсан хадгаламжууд орно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүний аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалт бүхий шинж чанартай буюу нэг өдрөөс дээш хугацаагаар ашиглах эрх нь хязгаарлалттай үлдэгдлүүдийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

Зээлийн авлагын хөрөнгө.

ББСБ нь олгосон зээлийн авлагын хөрөнгийн гэрээний нэг тал бөгөөд эдгээр зээлийн ирээдүйн үр ашиг (үүнд хүүний орлого орно) болон эрсдлийг өөртөө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнээр бүртгэнэ. Зээлийг анхлан хүлээн зөвшөөрсөнөөс хойш хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтыг ББСБ нь хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Зээлийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" бодлогын дагуу үнэлж тооцоолон тогтоодог.

Бусад авлага.

Худалдааны болон бусад авлагыг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Бусад өглөгүүд. Худалдааны өглөгүүд нь холбоотой тал гэрээний дагуух үүргээ биелүүлэх үед хуримтлагдсан үр ашигт хүүний аргын дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ.

Гадаад валютын хөрвүүлэлт. ББСБ-ын үйл ажиллагааны тайлагналын мөнгөн нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг болно. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн Монголбанкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн ашиг болон алдагдлыг орлогын тайланд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валютаар илэрхийлэгдсэн балансын дүнгүүдийг хөрвүүлсэн албан ханш 1 АМ.ДОЛ=3,444.60 төгрөг байна.

Дүрмийн сан болон хувьцааны нэмэгдэл.

Энгийн хувьцааг дүрмийн сангаар бүртгэнэ. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг татварын дараах дүнгээр нь хувьцаа борлуулсны орлогоос хассан дүнгээр өөрийн хөрөнгөд тусгана. Гаргасан хувьцааны бодит үнэ цэнийн нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг хувьцааны нэмэгдэл гэж өөрийн хөрөнгөд тусгана.

ЭРА АУДИТ Хуудас №

Хүүний орлого болон зардлын бүртгэл.

Өрийн бүх хэрэглүүрийн хувьд хүүний орлого болон зардлыг үр ашигт хүүний аргыг ашиглан аккруэл суурь дээр үндэслэн дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

Бусад бүх шимтгэлүүд болон орлого зарлага нь тухайн ажил үйлчилгээний үзүүлэх ёстой нийт үйлчилгээ болон үзүүлсэн үйлчилгээний гүйцэтгэлийн хувийн дагуу аккруэл сууриар бүртгэгддэг.

Боловсон хүчний зардал.

Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ББСБ нь Нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр зардлыг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Холбоотой талууд, гүйлгээ.

Хяналтын хувь оролцоог нэг этгээд эзэмшдэг, талуудыг эсвэл нэг тал нь нөгөө талыгаа хянах эрх мэдэлтэй эсвэл нөгөө талын санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргалтанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх эсвэл хамтарсан хяналт тавих боломжтой тохиолдолд тус талуудыг ерөнхийдөө холбоотой тал гэж үзнэ.

Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;

ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл

iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Компаний гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).

ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).

iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.

iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.

v) Аж ахуй нэгжийг (a)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.

(a) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.

vi) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Тайлант хугацааны дараах үйл явдал

НББОУС 10 Тайлагналын үеийн дараах үйл явдал – ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцооллыг тодруулна. Хэрэв санхүүгийн нөлөөллийн тооцоолол хийх боломжгүй бол тайлбар, тэмдэглэл хийгдэнэ. Удирдлага нь санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх тайлант хугацааны дараах үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсноос хойш 2023 оны 03 дугаар сарын 20–ны өдөр хүртэлх хугацаанд гараагүй гэж үзсэн.

Хуудас №

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

6.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

(мян.төгрөг)

Касс дахь мөнгө

№	Төрөл	валют	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	Бэлэн мөнгө	төгрөгийн	29,942	25,601
	Дүн		**29,942**	**25,601**

Банкин дахь мөнгө

№	Харилцагч банк	валют	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	ХААН БАНК	төгрөгийн	48,927	17,456
2	ХХ БАНК	төгрөгийн	64,792	50,526
	Дүн		**113,719**	**67,982**

6.2 ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨ

№	Зээл төрлөөр	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	Нийт зээл	1,836,281	1,695,725
2	Хэвийн зээл	1,380,062	1,451,329
3	Хугацаа хэтэрсэн зээл	56,468	9,360
4	Чанаргүй зээл	399,751	235,036
	-хэвийн бус	15,683	14,773
	-эргэлзээтэй	163,908	62,584
	- муу	220,160	157,678
5	Зээлийн эрсдлийн сан	(308,858)	(193,132)
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	52,040	21,388
	нийт дүн	**1,579,463**	**1,523,981**

6.3 БУСАД ХӨРӨНГӨ

№	Урьдчилгаа төлбөрүүд	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	Бусад авлага	269,630	1,428
2	Урьдчилж төлсөн тооцоо	135,989	150,657
	Дүн	**405,619**	**152,086**

Хуудас №
АУДИТ

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

үргэлжлэл

2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

6.4 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Дуусаагүй барилга	Компьютер, техник хэрэгсэл	Тавилга эд хогшил	Нийт дүн
1	**ӨРТГӨӨР**				
1.1	**Эхний үлдэгдэл**	**250,400**	**20,395**	**61,404**	**332,198**
	Нэмэгдсэн:		4,094	21,375	**25,469**
	үүнээс: Худалдан авсан		4,094	21,375	**25,469**
	Хасагдсан:	250,400		2,859	**253,259**
	үүнээс: Акталсан			2,859	**2,859**
1.2	**Эцсийн үлдэгдэл**	**-**	**24,489**	**79,920**	**104,409**
2	**ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ**				
2.1	Эхний үлдэгдэл	-	19,923	23,263	43,186
	Нэмэгдсэн				-
	үүнээс: Тайлант жилд байгуулсан		732	7,465	8,197
	Хасагдсан				-
2.2	Эцсийн үлдэгдэл	-	20,656	30,728	51,384
3	**ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН**				
3.1	Эхний үлдэгдэл	**250,400**	**471**	**38,141**	**289,012**
3.2	Эцсийн үлдэгдэл	**-**	**3,833**	**49,192**	**53,025**

Хуудас №

(мян.төгрөг)

6.5 БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ

№	Өглөгийн төрөл	2022.12.31-ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
1	Бусдад өгөх өглөг	4,215	2,473
2	ХАОАТ-ын өглөг	3,301	18,420
3	Орлогын албан татварын өглөг	19,658	25,082
	Дүн	**27,174**	**45,975**

6.6 ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Хувьцаа эзэмшигч МУ-ын иргэн Дашдорж овогтой Нарантунгалаг /РД:ХГ70060463/ дүрмийн сан нийт 1,900,000,000 төгрөг ба нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 190,00 ширхэг энгийн хувьцаатай.

7 ОРЛОГО

Орлогын төрөл	Тайлант оны дүн	Өмнөх оны дүн
7.1 ХҮҮГИЙН ОРЛОГО	**403,977**	**447,839**
Зээлийн хүү	403,977	447,839
7.2 ХҮҮГИЙН БУС ОРЛОГО		
Үйлчилгээний шимтгэлийн орлого	1,066	6,502
Бусад орлого - ЗЭСангийн буцаалт	114,577	-
Дүн	**115,643**	**6,502**

7.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний тодруулга

№	Хувьцаа эзэмшигчид	Харилцан хамаарал	гүйлгээний төрөл
1	МУ-ын иргэн Дашдорж овогтой Нарантунгалаг /РД:ХГ70060463/	Хувьцаа эзэмшигч,	Ногдол ашиг
2	МУ-ын иргэн Намхайнямбуу овогтой Шинэчимэг /РД:ТД76030800/	Гүйцэтгэх захирал	Цалин хөлс

Тайлант жилд холбоотой болон харилцан хамааралтай талуудтхий хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна.

№	Холбоотой талууд	гүйлгээний төрөл	2022 оны дүн
1	Хувьцаа эзэмшигч Д.Нарантунгалаг	зээл	103,600
		цалин хөлс	51,940
		ногдол ашиг	230,000
2	Гүйцэтгэх захирал Н.Шинэчимэг	цалин хөлс	28,380
		зээл	53,275
	нийт дүн		**467,195**

7.4 Болзошгүй хүчин зүйлс болон түүний үүрэг

ББСБ нь бизнесийн хэвийн үйл ажиллагааныхаа явцад ББСБ-аас нөхөн төлбөр төлөхийг шаардсан аливаа нэхэмжлэл хүлээн авах боломжтой. ББСБ-ын удирдлага өөрсдийн таамаглал болон мэргэжлийн зөвлөхийн зөвлөгөөнд үндэслэн ББСБ-д материаллаг хэмжээний хохирол учруулж болох аливаа зарга байхгүй гэж үзэж буй тул энэхүү санхүүгийн тайландаа болзошгүй өр төлбөрийн аливаа нөөц сан байгуулаагүй.

Хуудас №

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА үргэлжлэл

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

12/31/2022

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАН	ХАНГАСАН ЭСЭХ
А.	**ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**			
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	95.7%	Хангасан
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	95.7%	Хангасан
3	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	98.7%	Хангасан
Б.	**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА**			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	344.4%	Хангасан
В.	**АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү,- дутуу)	193,132	193,132	(0.0)
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	9.7%	Хангасан
7	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	13.3%	Хангасан
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	3.7%	Хангасан
Г.	**ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ**			
9	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	0.0%	Хангасан
Д	**ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			
10	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	2.5%	Хангасан
Е.	**ӨГӨӨЖ**			
11	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			6.6%
12	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			6.7%

Хуудас №
АУДИТ